

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоонд хууль,
эрх зүй, бүтэц зохин байгуулалтын шинэчлэл шаардлагатай байна.

АУДИТЫН КОД: /БУА-2021/15-5/-ШТА-ГА/

БУЛГАН ХОТ 2021 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын	
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр	
Утас: 70342580	Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn
Аудитын менежер Ж.Энхцоодол	
Утас: 70342716	Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор	Г.Намчинсүрэн
Утас: 70342716	Цахим хаяг: namchinsureng@audit.gov.mn
Ахлах аудитор	П.Содном
Утас: 70342716	Цахим хаяг: sodnomp@audit.gov.mn
Аудитор	З.Ганбаатар
Утас: 703427116	Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn
Аудитор	Б.Энхтөр
Утас: 703427116	Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёг.....	4
Зургийн товъёг.....	4
Дүрслэлийн товъёг.....	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	6
Ерөнхий мэдээлэл:.....	7
БҮЛЭГ 1. А.1. Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо оновчгүй, эрх зүйн орчин хангалтгүй, хараат бус бодитой баталгаажуулах байдал алдагдах эрсдэлтэй байна.....	8
А.1.1. Дотоод аудитын эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна.....	8
А.1.1.1.Төрийн байгууллагуудын дотоод аудитын хууль эрх зүйн зохицуулалтхангалтгүй, эрх зүйн заалтууд хоорондоо уялдаа холбоогүй байна.....	8
А.1.1.2. Дотоод аудитын дүрмийн хэрэгжилт хангалтгүй, холбогдох стандарттай бүрэн нийцэхгүй байна.....	9
А.1.2. Дотоод аудитын нэгж чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэ бүтэц, хөрөнгө хүний нөөцийн боломж хангагдаагүй байна.....	11
А.1.2.1. Дотоод аудитын нэгж чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэх боломжтой бүтэц, хөрөнгө, хүний нөөц хангалтгүй байна.....	11
А.1.2.2. Дотоод аудитын нэгж үйл ажиллагаагаа хараат бусаар удирдах, хэрэгжүүлэх, хянах, тайлагнах нөхцөл бүрэн бүрдээгүй байна.....	12
А.1.2.3. Булган аймгийн хэмжээнд дотоод аудитын дүрэмд заасан шалгуурыг хангасан дотоод аудитор байхгүй байна.....	12
БҮЛЭГ 2. А.2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь үйл ажиллагаанд чанарын хяналтын үнэлгээ, дотоод аудитыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.....	13
А.2.1. Дотоод аудит хийгдээгүйтэй холбоотой чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.....	13
А.2.1.1. Дотоод аудитын нэгж нь үйл ажиллагаагаа дүрэм, стандартын дагуу явуулж байгаа ч зарим зүйл заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.....	13
А.2.1.2. Дүрэмд заасан чиг үүргийг оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.....	14
А.2.1.3. Зохион байгуулалт, хууль эрх зүйн орчноос хамаарч хараат бус байдал алдагдах, ашиг сонирхолын зөрчил үүсэх, дүгнэлтийн үнэн зөв бодитой байх чанар алдагдах эрсдэлтэй байна.....	16
А.2.1.4. Хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд, ил тод мэдээлэх ажил хангалтгүй, мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна.....	16
А.2.1.5. Дотоо аудитын дүрэмд төрийн аудитын байгууллагатай хамтран ажиллаж болохоор тусгасан ч уялдаа холбоотой ажиллаагүй байна.....	17
А.2.2. Эрх бүхий байгууллагаас дотоод аудитын үйл ажиллагаанд мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээ хийгдээгүй, Санхүү хяналт дотоод аудитын албаны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал дахин давтагдаж байгаа нь хяналтын үр нөлөөг бууруулж байна.....	17
А.2.2.1.Төрийн захиргааны төв байгууллагаас дотоод аудитын үр дүнд үнэлгээ хийж, дүгнэлт өгч ажиллаагүй байна.....	17
А.2.2.2. Төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг тооцохдоо албан бичгээр хаадаг, албан шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын нотлох баримт хангалтгүй байгаа нь илэрсэн алдаа зөрчил бодит байдал дээр арилаагүй байна.....	17
А.2.2.3. Санхүү хяналт дотоод аудитын албаны хяналт шалгалтаар илэрсэн төлбөрийн акт, албан шаардлагаар тогтоосон зөрчил дутагдал дахин давтагдаж байгаа нь хяналтын үр нөлөөг бууруулж байна.....	19
Байгууллагын санал:.....	20
Саналд өгсөн тайлбар:.....	20
ДҮГНЭЛТ:	21
ЗӨВЛӨМЖ:.....	21
Хавсралтууд:.....	23

Товчилсон үгийн тайлбар

ЗГ	Засгийн газар
ДАМПОУС	Дотоод аудитын Мэргэжлийн Практикийн Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ГХБХБГ	Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтэц, баталсан орон тооны судалгаа	12
Хүснэгт 2	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2016-2020 оны хяналт, шалгалтын төлөвлөгөө, гүйцэтгэл	14

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны “ http://sankhuuhyanalт.bu.gov.mn ” веб сайт	17

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны төлбөрийн актын мэдээлэл	19
Дүрслэл 1	Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны албан шаардлагын мэдээлэл	19

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Судалгааны маягт	23
Хавсралт 2	Санал, асуулгын нэгтгэл	24

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/27 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, “Булган аймаг дахь Төрийн Аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн хийв.
Аудитын зорилт	Аудитын зорилт Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: ➤ Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо оновчтой эсэх; ➤ Төрийн байгууллагууд дотоод аудитын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад төрийн байгууллагуудын дотоод аудитын зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид болон тэдгээрийн харьяа агентлаг, байгууллагуудын дотоод аудитын үйл ажиллагааны мэдээлэл, тайлан, тоон өгөгдөл болон бусад нотлох баримтад үндэслэн дүн шинжилгээ хийж аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Д.Анхбаяр удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Намчинсүрэн, П.Содном, аудитор Б.Энхтөр, З.Ганбаатар нар гүйцэтгэв. Аудитын төлөвлөгөөний дагуу талбарын ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ.

Ерөнхий мэдээлэл:

Дотоод Аудиторуудын Олон Улсын Институтээс 2017 онд бүрэн хэмжээний өөрчлөлт оруулсан Дотоод Аудитын Мэргэжлийн Практикийн Олон Улсын Стандарт (ДАМПОУС)-д “Дотоод аудит”-ыг “Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой баталгаа өгөх, зөвлөх үйл ажиллагаа, дотоод хяналтын үйл явцыг үнэлэн, хараат бус үнэлгээ өгөх зорилгоор зохих нотолгоонд үндэслэн хийж байгаа шалгалт” гэж тодорхойлжээ.

Харин Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд дотоод аудитын талаар дараах заалтуудыг заасан байна. Үүнд:

69.1. Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна;

69.2. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангана;

69.3. Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна;

69.4. Дотоод аудитор нь санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхтэй байна;

69.5. Дотоод аудитын албаны дүрмийг Засгийн газар батална.

Мөн 2012 оны Засгийн газрын 129 дүгээр тогтоолоор “Дотоод аудитын дүрэм”-ийг баталсан бөгөөд уг дүрмийн 1.1-д “Энэхүү дүрэм нь Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт болон дотоод аудиторын эрх, үүргийг тодорхойлж, дотоод аудитын үйл ажиллагааг явуулах, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтарч ажиллах зэрэг харилцааг зохицуулна.” гэж заасан байна. 2015 оны Засгийн газрын 483 дугаар тогтоолоор “Дотоод аудитын дүрэм”-ийг шинэчлэн баталсан бөгөөд дүрмийн 1.1-д “Энэхүү дүрэм нь төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч бүрийн дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт, дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрх, үүргийг тодорхойлж, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулах, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтарч ажиллахтай холбогдох харилцааг зохицуулна.” гэж заажээ.

Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар “Санхүүгийн хяналт, шалгалтын стандарт”, 2019 оны 29 дүгээр тушаалаар “Дотоод аудитын хорооны дүрэм”, 2019 оны 268 дугаар тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, 2019 оны 274 дүгээр тушаалаар “Дотоод аудитын чанарын үнэлгээ хийх журам”, “Чанарын үнэлгээний аргачлал”-ыг тус тус баталсан байна.

БҮЛЭГ 1. А.1. Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо оновчгүй, эрх зүйн орчин хангалтгүй, хараат бус бодитой баталгаажуулах байдал алдагдах эрсдэлтэй байна.

А.1.1. Дотоод аудитын эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна.

А.1.1.1.Төрийн байгууллагуудын дотоод аудитын хууль эрх зүйн зохицуулалт хангалтгүй, эрх зүйн заалтууд хоорондоо уялдаа холбоогүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь Төсвийн тухай хууль 69.1¹, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9.8², 10.12.4³ дахь заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрэм, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66.4⁴, Сангийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 107 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас бусад төрийн байгууллагуудын хувьд Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. /Судалгааны маягт-1/

Дотоод аудитын албаны эрх зүйн харилцааг зохицуулж байгаа хуулийн заалт, дүрэм, журам нь хоорондоо бүрэн нийцээгүй, уялдаа муу, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуулийн 69.1, Дотоод аудитын дүрмийн 2.1⁵-д дотоод аудитын чиг үүрэгт санхүүгийн хяналт шалгалтын чиг үүргийн гүйцэтгэхээр тодорхойлсон нь Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартад заасан “Дотоод аудит нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулж, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой баталгаажуулах ба зөвлөх үйлчилгээ мөн. Дотоод аудит нь эрсдэлийн удирдлага, хяналт, засаглалын үйл явцын үр нөлөөг үнэлж сайжруулах системтэй, цэгцтэй арга хандлагыг нэвтрүүлэх замаар зорилтуудаа биелүүлэхэд нь байгууллагад тусална” гэж тодорхойлсонтой бүрэн нийцээгүй,

¹ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

² .хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;

³ ноцтой осол аюул гарсан, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, их хэмжээний хор хохирол учирсан тохиолдолд болон илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

⁴ Сангийн яам нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд баримтын иж бүрэн шалгалтыг 2 жил тутам нэгээс доошгүй удаа заавал хийх ба шалгалтын дүнг хамтран хэлэлцэж шаардлагатай арга хэмжээ авна.

⁵ Дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

- ТЕЗ-ийн харьяа хяналт шинжилгээ дотоод аудитын хэлтэс нь “дотоод аудит” гэсэн чиг үүргийг огт хэрэгжүүлдэггүй, дотоод аудит хийх эрх зүйн зохицуулалт байхгүй,
- Улсын салбарын дотоод аудитын гарын авлагыг баталсан боловч төрийн байгууллагууд тухайн гарын авлагыг огт хэрэглэдэггүй,
- Дотоод аудитын тухайн жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөг Дотоод аудитын хорооны дүрмийн 4.1.1⁶-д ТЕЗ, Дотоод аудитын дүрмийн 7.1⁷-д аудитын хороо батлахаар байгаа нь хоорондоо нийцээгүй, хэрхэн уялдаж байгаа нь тодорхойгүй,
- Санхүүгийн хяналт шалгалт, аудитын албаны хяналт шалгалтын улсын байцаагч, ахлах байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9.8, 10.2.12 дах заалтыг үндэслэн акт, албан шаардлага тавьж байгаа нь дотоод аудитын дүрэмтэй огт уялдаагүй, эрх зүйн зохицуулалт байхгүй,
- Дотоод аудитын дүрмийн 6.3.1⁸-д заасан заалтыг бүрэн хэрэгжүүлэх эрх зүйн орчин байхгүй учир шалгагдагч байгууллагатай маргаан үүсэхэд шийдвэр /акт, албан шаардлага/ нь хүчингүй болох эрсдэлтэй,
- Дотоод аудитын дүрмийн 7.8⁹-д “...дотоод аудитор нь хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмж, түүний мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтэд улирал тутам хяналт тавьж ажиллана” гэж заасан боловч хуулиар олгосон эрх зүйн үндэс байхгүй,
- Монгол улсын хэмжээнд дотоод аудитын үндэсний стандарт байхгүй байна.

Цаашид дотоод аудитын хууль эрх зүйн орчныг тодорхой болгож дотоод аудитын эрх зүйн бие даасан дотоод аудитын тухай хуультай болох шаардлагатай байна.

А.1.1.2. Дотоод аудитын дүрмийн хэрэгжилт хангалтгүй, холбогдох стандарттай бүрэн нийцэхгүй байна.

Дотоод аудитын нэгжийн бүтэц, зохион байгуулалт, эрх, үүрэг, үйл ажиллагааны цар хүрээ зааг, баримтлах бодлого, стандартыг Дотоод аудитын дүрмээр зохицуулдаг байна. /эх сурвалж Б.Батбаяр “Дотоод аудит” ном/.

ЗГ-ын 2015 оны 486 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрэмд дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, зарчим, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн чиглэл, дотоод аудитуудын эрх үүрэг, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар тусгайлан оруулж өгсөн ч уг дүрмийн зарим заалт огт хэрэгждэггүй, дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын зарим

⁶ Дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны 3-н жилийн болон тухайн жилийн төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

⁷ Дотоод аудитын нэгж нь тухайн жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөтэй байх бөгөөд төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагч батална.

⁸ Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэл болон нэг бүрчилсэн акт, танилцуулга, аудитын зөвлөмжийг хууль тогтоомж болон баримт нотолгоонд үндэслэн гаргах;

⁹ Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч, дотоод аудитор нь хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмж, түүний мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтэд улирал тутам хяналт тавьж ажиллана.

стандарт огт тусгагдаагүй, мөн дотоод аудитын нэгжийн загвар дүрэмтэй бүрэн нийцээгүй байна. Үүнд:

- Дотоод аудитын дүрмийн 2¹⁰-д заасан дотоод аудитын үйл ажиллагааны зорилго нь дотоод аудиторчуудын институтын дотоод аудитын тодорхойлолттой¹¹ нийцээгүй,
- Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартад Дотоод аудитын нэгж бүр нь өөрийн гэсэн дүрэмтэй байна, дотоод аудитын дүрмийг үе үе эргэн хянаж, ахлах удирдлага болон зөвлөлд танилцуулахаар заагдсан байдаг боловч ТЕЗ-ын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь стандартын дагуу өөрийн дотоод аудитын дүрэмгүй байна,
- Дотоод аудитын дүрэмд заасан дотоод аудитын нэгжийн удирдлага, зохион байгуулалт, хамрах хүрээний талаар заасан заалтууд нь дотоод аудитын нэгжийн загвар дүрэмтэй бүрэн нийцээгүй, аудитын гүйцэтгэх удирдлагын хүлээх үүргийг нарийвчлан тодорхойлоогүй,
- Дотоод аудитын дүрмийн 3¹²-д заасан үйл ажиллагааны зарчимд хараат бус байдал ба бодит хандалга /Стандарт-1100/, зохион байгуулалт ба хараат бус /Стандарт -1110/ байдал, хараат бус байдал буюу бодитой хандлага алдагдах /стандарт-1130/ талаар огт тусгаагүй,
- Дотоод аудитын дүрмийн 7.3¹³-д дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг холбогдох олон улсын стандарт, хууль журмыг баримтлан гүйцэтгэнэ гэж заасан боловч дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартыг хэрэгжүүлэн ажиллахгүй зөвхөн ЗГ-ын 2016 оны 03 дугаар сарын „107 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ыг мөрдөн ажилладаг,
- Санхүүгийн хяналт, дотоод аудитын албан нь байгууллагын эрсдэлийг тодорхойлж эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхээр заасан боловч ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын төсөв, хөрөнгийн зарцуулалт холбогдох хууль журамд нийцсэн эсэхэд голчлон чиглэн хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулдаг,
- Дотоод аудитын дүрэм 6.2.1¹⁴-д олон улсын дотоод аудиторчуудын институтээс гаргасан санхүүгийн хяналт шалгалт улсын байцаагчийн ёс зүйн дүрмийг баримталж ажиллах гэсэн боловч зөвхөн дотоод аудитын ёс зүйн дүрмийг баталж гаргадаг нь эрх зүйн зохицуулалтын хувьд уялдаа холбоогүй байна.

Дээрхээс дүгнэхэд дотоод аудитын нэгжийн дотоод аудитын дүрмийг ДАМПОУС –д нийцүүлэн засаглалын үр нөлөө, үр ашиг, эрсдэлийн удирдлага

¹⁰ Дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

¹¹ Дотоод аудит нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулж, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хараат бус, бодитой баталгаажуулах ба зөвлөх үйлчилгээ юм.

¹² Дотоод аудитын үйл ажиллагаа нь ил тод, бие даасан, хараат бус байж, хяналт шалгалт, аудитын дүнг бодитой, үнэн зөв, шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчим баримтална.

¹³ Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг холбогдох олон улсын стандарт, хууль, журмыг баримтлан гүйцэтгэнэ.

¹⁴ үйл ажиллагаандаа хууль тогтоомж, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, олон улсын Дотоод аудиторчуудын институтээс гаргасан санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн болон дотоод аудиторын ёс зүйн дүрмийг чанд баримтлах;

болон хяналтын үйл явцад хувь нэмэр оруулж байхаар өөрчлөн шинэчлэх шаардлагатай байна.

А.1.2. Дотоод аудитын нэгж чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх бүтэц, хөрөнгө хүний нөөцийн боломж хангагдаагүй байна.

А.1.2.1. Дотоод аудитын нэгж чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэх боломжтой бүтэц, хөрөнгө, хүний нөөц хангалтгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дараах бүтэц, орон тоотой байгуулагджээ.

Тус алба нь 2015-2020 он хүртэл нийт бүтцэт заагдсан орон тоог ТЭЗ бүрэн батлаагүй тул дутуу орон тоотойгоор чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны бүтэц, баталсан орон тооны судалгаа

								/Хүснэгт-1/	
Албан тушаалын ангилал	Албан тушаал		Бүтцэт заагдсан орон тоо	Төсвийн ерөнхийлөн баталсан орон тоо					
				2015	2016	2017	2018	2019	2020
Удирдах	Албаны дарга		1	1	1	1	1	1	1
Гүйцэтгэх	СХШ-ын байцаагч	Улсын	1	1	1	1	1	1	1
Гүйцэтгэх	СХШ-ын байцаагч	Улсын	1	1	1	1	1	1	1
Гүйцэтгэх	СХШ-ын байцаагч	Улсын	1	1	1	1	1	1	1
Гүйцэтгэх	СХШ-ын байцаагч	Улсын	1	1	1	1	1	1	1
Гүйцэтгэх	Дотоод аудитор		1						
Гүйцэтгэх	Дотоод аудитор		1						
Үйлчлэх	Нягтлан бодогч, хүний нөөц, бичиг хэрэг		1					1	1
Үйлчлэх	Жолооч		1						1
Нийт дүн			9	5	5	5	5	6	7

Иэх сурвалж: Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба/

Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын алба нь аймгийн хэмжээнд хяналт, шалгалт, дотоод аудитад хамрагдах ТЭЗ, ТТЗ-ийн харьяа төсвийн шууд захирагч, эргэлтийн эмийн сан, улс орон нутгийн тусгай сангууд зэрэг нийт 244 шалгагдагч байгууллага байдаг ба ТБОНӨТХ-ийн 66.4-д заасны дагуу иж бүрэн шалгалтыг 2 жил тутамд нэгээс доошгүй удаа заавал хийнэ гэсний дагуу тооцож үзэхэд жилдээ дунджаар 135 байгууллагад хяналт шалгалт хийхээр байдаг ч Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ын 3.1.3¹⁵-д заасан хугацаагаар тооцож үзэхэд 1 байцаагч жилдээ 10-12 байгууллагад буюу нийт шалгалтад хамрагдах байгууллагынхаа 54 хувийг жилийн төлөвлөгөөндөө тусгадаг байна.

¹⁵ Хяналт шалгалт явуулах хугацааг тогтоосон байна. Энэ хугацааг тогтоохдоо шалгалтын тайлан гаргах хугацааг тооцно.

Энэ нь шалгагдагч байгууллагын тоотой хамааруулж нэгжийн бүтэц, орон тоог зохион байгуулаагүй, бүтцэт заасан орон тоог ТЕЗ бүрэн батлаагүйгээс тухайн нэгжийн санхүүгийн хяналт шалгалтын ажлын ачаалал их, дүрэмд заасан дотоод аудитын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэж байна.

Мөн ТЕЗ-аас тухайн жилийн урсгал зардлыг батлахдаа төсвийн төсөлд өгсөн саналыг харгалзахгүй зөвхөн өмнөх жилийн гүйцэтгэлд үндэслэн төсвийг баталдгаас үндсэн чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай машин техник, тоног, төхөөрөмжийн асуудлыг шийдэх хөрөнгийн асуудал хүндрэлтэй, мөн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдэх хөрөнгийг төсөвт тусгадаггүй зэргээс дүгнэхэд Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба аудитын дүрэм, бусад стандартад заагдсан дотоод аудитын чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд хөрөнгө, хүний нөөц, хүрэлцдэггүй, хангалтгүй байна. /хавсралт-1/

А.1.2.2. Дотоод аудитын нэгж үйл ажиллагаагаа хараат бусаар удирдах, хэрэгжүүлэх, хянах, тайлагнах нөхцөл бүрэн бүрдээгүй байна.

Дотоод аудитын дүрмийн 4.12¹⁶-д заасны дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 28 дугаар тогтоолоор дотоод аудитын хорооны гишүүдийг шинэчлэн баталсан байна.

Дотоод аудитын дүрмийн 4 дүгээр заалтын дотоод аудитын хорооны эрх үүргээс дүгнэхэд дотоод аудитын нэгжийн чиг үүргийн хэрэгжилт нь дотоод аудитын хорооны үйл ажиллагаанаас шууд хамааралтай байгаа бөгөөд гишүүдийн хараат бус байдал нь чухал ач холбогдолтой байна.

Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар “Дотоод аудитын хорооны дүрэм”-ыг баталсан бөгөөд дүрмийн 2.2-т хорооны бүрэлдэхүүнд нийт гишүүдийн гуравны нэгийг хараат бус гишүүдээр бүрдүүлнэ гэж заасны дагуу бүрдүүлсэн байна.

Аймгийн аудитын хороо нь шинэчлэн байгуулагдсанаас хойш 2021 он хүртэл нэг удаа хуралдсан, орон нутгаас урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлдэг, дотоод аудитын нэгжийн даргын төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн гэрээг ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ-дотоод аудитын хэлтэс үнэлж байгаа нь Санхүүгийн хяналт, аудитын албаны зохион байгуулалтын хараат бус байдал хангагдаагүй байна.

Иймд цаашид аймгийн аудитын хороо санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагааг хараат бусаар удирдах, хэрэгжүүлэх, хянах, тайлагнах, зохион байгуулалтын хараат бус байдлыг хангах эрх үүргээ бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

А.1.2.3. Булган аймгийн хэмжээнд дотоод аудитын дүрэмд заасан шалгуурыг хангасан дотоод аудитор байхгүй байна.

Аймгийн Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 20-ны Б/12 тоот захирамжаар Санхүүгийн хяналт, дотоод аудитын бүтцэт хоёр дотоод аудиторын орон тоог баталсан боловч одоогоор Засгийн газрын 2015 оны 483 дугаар

¹⁶ Төсвийн ерөнхийлөн захирагч дэргэдээ Дотоод аудитын хороотой байж болох бөгөөд хороог тухайн төсвийн ерөнхийлөн захирагч даргална.

тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ын 4.4¹⁷-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасан дотоод аудитор байхгүй байна.

Энэ нь Хуулийн этгээдийн дүрэмд 2 аудитор байна гэж заасан боловч ТЕЗ орон тоог баталдаггүйтэй холбоотой байна.

Иймд санхүүгийн хяналт, дотоод аудитын нэгж нь үндсэн чиг үүргийнхээ хүрээнд Дотоод аудитын олон улсын стандартад¹⁸ нийцүүлэн дотоод аудиторыг томилон дотоод аудитын дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна. БҮЛЭГ 2. А.2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь үйл ажиллагаанд чанарын хяналтын үнэлгээ, дотоод аудитыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

А.2.1. Дотоод аудит хийгдээгүйтэй холбоотой чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

А.2.1.1. Дотоод аудитын нэгж нь үйл ажиллагаагаа дүрэм, стандартын дагуу явуулж байгаа ч зарим зүйл заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Монгол Улсын засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан дотоод аудитын дүрмийн 7.1 дэх “Дотоод аудитын нэгж нь тухай жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөтэй байх бөгөөд төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагч батална” гэж тусгажээ.

Булган аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Засаг даргаар жил бүр тухай онд гүйцэтгэх хяналт шалгалт, дотоод аудитын графикийг батлуулдаг ч дунд хугацааны төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Тухай жилд хяналт шалгалт, дотоод аудит хийх байгууллагыг төлөвлөхдөө Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.4¹⁹-д заасныг баримтлдаг байна.

Жилийн төлөвлөгөөнд тусгасан аудитын удирдамжийг тухай төсвийн ерөнхийлөн захирагч батлахаар дүрэмд тусгасан ч санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга удирдамжийг баталж байгаа нь “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.2²⁰ дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2016-2020 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

/Хүснэгт-2/

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Хэрэгжээгүй
		Төлөвлөгөөт	Төлөвлөгөөт бус	
2016		40	5	
2017	49	43	7	6

¹⁷ Дотоод аудитор нь санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, тухайн салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний зөвшөөрлөөр албан ёсоор зохион байгуулсан сургалтад хамрагдсан байна.

¹⁸ Эх сурвалж: Улсын салбарын дотоод аудитын гарын авлага

¹⁹ 66.4-д заасан “Сангийн яам нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд баримтын иж бүрэн шалгалтыг 2 жил тутам нэгээс доошгүй удаа заавал хийх ба шалгалтын дүнг хамтран хэлэлцэж шаардлагатай арга хэмжээ авна.”

²⁰ 7.2. Дотоод аудитын жилийн төлөвлөгөөнд тусгасан аудитын удирдамжийг тухайн төсвийн ерөнхийлөн захирагч батална

2018	49	38	8	11
2019	62	50	4	12
2020	53	47	4	6

Санхүүгийн хяналт шалгалтыг 5 жилийн хугацаанд төлөвлөгөөт 218, төлөвлөгөөт бус 28 нийт 246 байгууллагад хяналт шалгалт хийж, үүнээс төлөвлөгөөт 35 байгууллагад хийх хяналт шалгалт тасарсан нь төлөвлөгөөт бус хяналт шалгалт нэмэгдсэн мөн дотоод аудитын ажилтангүйгээс дотоод аудитууд хийгдээгүйтэй холбоотой байна.

Хяналт шалгалтаар тухайн 5 жилд нийт 534,705.3 мянган төгрөгийн 394 төлбөрийн акт тогтоож, 524,530.7 мянган төгрөгийн 129 албан шаардлага өгсөн байна.

2016-2020 оны актын биелэлт нь өссөн дүнгээр 90.2 хувь нь биелж, 64,274.6 мянган төгрөгийн төлбөрийн актын үлдэгдэлтэй, албан шаардлагын биелэлт 100 хувь хэрэгжсэн үзүүлэлттэй байна.

Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч, дотоод аудитор нь хяналт шалгалт, аудитын тайланг бэлтгэн нэгжийн даргад танилцуулна. Хэрэв Дотоод аудитын хороотой бол тайланг тус хороогоор хэлэлцүүлэхээр дотоод аудитын дүрэмд заасан байна.

Мөн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга нь аудитын хороо, төсвийн ерөнхийлөн захирагчид хяналт шалгалтын дүн, нэгжийн жилийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн явц, холбогдох акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн явц, аудитад хамрагдсан байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд анхаарах асуудал зэргийг танилцуулж тайлагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан ч дотоод аудитын хорооноос ямар нэгэн хяналт шалгалттай холбоотой асуудлыг хэлэлцсэн тухай тогтоол шийдвэр гараагүй байна.

Санхүүгийн хяналт шалгалт, аудитын нэгж нь Сангийн яамны санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хагас, бүтэн жилээр үйл ажиллагааны тайлан, зөрчлийн мэдээг хүргүүлжээ.

А.2.1.2. Дүрэмд заасан чиг үүргийг оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5 дугаар зүйл, Сангийн сайдын 2016 оны 107 тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-д дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:

- ✓ Хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдал,
- ✓ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдал,
- ✓ төсвийн санхүүжилт, зарцуулалт, төрийн сангийн үйл ажиллагааны үнэн зөв байдал,
- ✓ төсвийн ерөнхийлөн захирагч болон тухайн байгууллагын шийдвэрээр тусгайлан явуулах аудит,
- ✓ байгууллагын дотоод хяналт, засаглалын байдалд болон холбогдох стандартын хүрээнд тодорхойлсон бусад аудит,
- ✓ эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, заавар, стандарт, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих,

- ✓ төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын өглөг, авлагын байдал,
- ✓ орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, хөрөнгийн зарцуулалт, төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдал,
- ✓ анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайланд хяналт тавих;
- ✓ Засгийн газрын тусгай сан, төсвөөс олгосон санхүүгийн тусламж, дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө, олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандив, тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих;

Дээр дурдсан чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлдэг талаар Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2020 онд гүйцэтгэсэн хяналт шалгалтын материалаас удирдамж, төлөвлөгөө танилцуулга, анхан шатны баримт болон асуулга, ярилцлагад тулгуурлан аудитын явцад тодрууллаа. /Хавсралт-2/

Хяналт шалгалтын удирдамжид санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төв байгууллагаас гаргасан заавар журам, анхан шатны баримтын бүрдэл хөтлөлт, тайлан тэнцэл гаргалт, орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, данс бүртгэлд тусгасан байдал, өглөг, авлагын байдал зэрэг чиг үүргийг хяналт шалгалтын удирдамжид бүрэн тусгаж ажилласан байна.

Хяналт шалгалтын танилцуулгад дээрх чиг үүргүүдээс төсөв санхүүжилт, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдал, байгууллагын өглөг, авлагын байдал, санхүүгийн тайланд хяналт тавих, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт зэрэгт хяналт шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгах, нөхөн төлүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

Гэвч дээр дурдсанаас бусад чиг үүргийг шалгалтын явцад хэрхэн гүйцэтгэсэн, нөхцөл байдал, зөрчил дутагдал байгаа эсэх талаар хяналт шалгалтын баримт материалд байхгүй, танилцуулгад дурдагдаагүй, дотоод аудит хийгдээгүй байгаа нь чиг үүргээ оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын дүрэмд тусгасан чиг үүргийг үйл ажиллагаандаа хэрхэн хэрэгжүүлдэг талаар санхүүгийн хяналт, аудитын албаны ажилтнуудаас асуулга хэлбэрээр 2 бүлэг 14 асуултаар авахад НББ тухай хууль, Төсвийн тухай хууль тэдгээртэй холбогдуулан гаргасан дүрэм, журмын хэрэгжилтийг шалгагдаж байгууллагаас гарсан тушаал, шийдвэрийн заалтыг үзэх, эд хөрөнгийн тооллогын данс бүртгэлтэй тулгах, батлагдсан төслийн хүрээнд зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалт, төсвийн үйл ажиллагааны үр дүнтэй зарцуулагдаж байгаа байдал, тухайн байгууллагын дотоод хяналт шалгалт аудит, хууль тогтоомжид нийцээгүй тушаал, шийдвэр, илэрсэн алдаа зөрчлийг арилгуулж, өглөг авлагыг барагдуулах, гарсан зөрчилд хугацаатай акт, албан шаардлага хүргүүлж, төсвийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт, батлагдсан төсвийг төлөвлөгөөний дагуу зарцуулсан байдал, анхан шатны баримтын бүрдэл, хандив, тусламж, үнэ төлбөргүй хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байдлыг хяналт шалгалтаар анхан шатны баримттай тулган баталгаажуулж тогтоож байна гэж асуулгад хариулсан байна. /Хавсралт-3/

А.2.1.3. Зохион байгуулалт, хууль эрх зүйн орчноос хамаарч хараат бус байдал алдагдах, ашиг сонирхлын зөрчил үүсэх, дүгнэлтийн үнэн зөв бодиттой байх чанар алдагдах эрсдэлтэй байна.

Хяналт шалгалтын байгууллагын хараат бус байдал нь зохион байгуулалт, хууль эрх зүй, албан хаагчдын хувийн зохион байгуулалт зэргээр тодорхойлогддог ба хяналт шалгалтын байгууллагын хараат бус байдлын талаар Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоол баталсан дотоод аудитын дүрмийн зарчимд, Сангийн сайдын 107 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ын 5-д зохицуулжээ.

Санхүүгийн хяналт, аудитын албаны хувьд хяналт шалгалтын байгууллагын зорилго, бүтэц, зохион байгуулалт, эрх үүрэг, хариуцлагыг хуульчилж батлаагүй, байгууллагын дүрэмд тусгасан орон тооноос 2 аудитор төсөв санхүүжилттэй холбоотой дутуу ажилласан байна.

Тус алба нь хяналт шалгалтыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх бүрд сонирхлын зөрчилгүй мэдэгдэл гарган ажилладаг ч ихэвчлэн 1 байгууллагад 1 байцаагч хяналт шалгалтыг хийдэг мөн дарга буюу хяналт шалгалтын улсын ахлах байцаагч төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зарим тохиолдолд ганцаараа хийж байгаа нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.5²¹ дахь заалтын дагуу баг бүрэлдэхүүнийг байгуулаагүй, хяналтын тогтолцоо, хараат бус байдал алдагдаж байна.

Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ бүх үйл ажиллагааг баримтжуулахаар дүрэмд тусгасан ч хяналт шалгалтын үе шатны хяналтууд хийсэн тухай баримт материал байхгүй, хараат бус байдал алдагдах, ашиг сонирхлын зөрчил гарах, ажлын үнэ зөв, бодиттой байх чанар алдагдах эрсдэл байна.

А.2.1.4. Хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд, ил тод мэдээлэх ажил хангалтгүй, мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд мэдээллээ ил тодоор мэдээлэх үүрэг хүлээдэг.

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь <http://sankhuuhyanalt.bu.gov.mn> веб сайтыг 2018 оноос ашиглаж эхэлсэн ба тус сайтад хяналт шалгалтын жилийн төлөвлөгөө, хяналт шалгалтын дүнгийн танилцуулга, төлөвлөгөөт бус хяналт шалгалт, цаг үеийн мэдээ, мэдээлэл зэргийг байршуулж байна.

10 сар 20, 2021



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
АУДИТЫН АЛБА**

САЙТЫН БҮТЭЦ

- Мэдээ, мэдээлэл (20)
- Зарлал (2)
- Цаг үеийн мэдээ (18)
- Онцлох мэдээ (4)
- Тайлан мэдээ (25)
- Санхүүгийн хяналт, шалгалтын тайлан (25)

ТАНИЛЦУУЛГА - МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ - ИЛ ТОД БАЙДАЛ - ЭРХ ЗҮЙН АКТ - ШИЛЭН ДАНС



21 5.2.5. шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч;

**Санал, хүсэлт, өргөдөл, гомдол
хүлээн авч байна**

Санхүүгийн хяналт, аудитын албаны үйл ажиллагаанд үнэлгээ өгнө үү.

☐ Маш сайн

☐ Сайн

☐ Дунд

☐ Муу

Илгээх

2018-2019 онуудад 100 байгууллагад хяналт шалгалт хийсний 25 танилцуулгыг олон нийтэд мэдээлсэн, 2020 онд хяналт шалгалт хийсэн 51 байгууллагын хяналт шалгалтын дүнгийн танилцуулгыг огт мэдээлээгүй байна. Веб сайт ашиглаж эхэлсэн хугацаанаас хойш хийсэн нийт 151 байгууллагын хяналт шалгалтын танилцуулгаас 25 буюу 16.5 хувийг олон нийтэд мэдээлсэн нь ил тод мэдээлэх ажил хангалтгүй байна.

Цаг үеийн мэдээ, мэдээллийг “sankhuu audit bulgan” фээсбүүк ашиглан олон нийтэд мэдээлдэг ч цаашид ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

А.2.1.5. Дотоод аудитын дүрэмд төрийн аудитын байгууллагатай хамтран ажиллаж болохоор тусгасан ч уялдаа холбоотой ажиллаагүй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын нэгж нь 2015 онд байгуулагдсан дотоод аудитыг хэрэгжүүлдэг төрийн байгууллагатай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцсон ажил байхгүй, нэгжийн даргатай хийсэн ярилцлагад аймгийн Татварын хэлтэс нь өөрийн хуулийн хүрээнд гарсан зөрчлийг салбарын хяналт шалгалтын улсын байцаагч нь шийдвэрлэж байх санал тавьдаг ч энэ талаарх зохицуулсан хууль эрх зүйн орчин байхгүй тул санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нь эрхийнхээ хүрээнд зөрчлийг шийдвэрлэж байна.

Дотоод аудитын дүрэмд хөндлөнгийн аудитын байгууллагатай жилийн ажлын төлөвлөгөө, тайланг харилцан мэдээлэх, сургалт зохион байгуулах, харилцан мэдээлэл солилцох хүрээнд хамтран ажиллаж болохоор тусгасан ч энэ хүрээнд хийсэн ажил байхгүй байна.

А.2.2. Эрх бүхий байгууллагаас дотоод аудитын үйл ажиллагаанд мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээ хийгдээгүй, Санхүү хяналт дотоод аудитын албаны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал дахин давтагдаж байгаа нь хяналтын үр нөлөөг бууруулж байна.


А.2.2.1.Төрийн захиргааны төв байгууллагаас дотоод аудитын үр дүнд үнэлгээ хийж, дүгнэлт өгч ажиллаагүй байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанд Засгийн газрын 2015 оны 483 тогтоолын 8 дугаар зүйлийн 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэсэн заасан 2016-2020 онуудад аудитын үр дүнд үнэлгээ, дүгнэлт хийгээгүй байна.

А.2.2.2. Төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг тооцохдоо албан бичгээр хаадаг, албан шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын нотлох баримт хангалтгүй байгаа нь илэрсэн алдаа зөрчил бодит байдал дээр арилаагүй байна.


Санхүү хяналт дотоод аудитын 2016-2020 онд хийсэн хяналт шалгалтаар өссөн дүнгээр нийт 656,283.9 төлбөрийн акт, 524,530.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлагыг тус тус бүртгэж ирсэн ч зөвлөмжийн бүртгэл байхгүй байгаа нь Засгийн газрын 2015 оны 483 тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3.1. “санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэл болон нэг бүрчилсэн акт, танилцуулга, аудитын зөвлөмжийг хууль тогтоомж болон баримт нотолгоонд үндэслэн гаргах”, 7

дугаар зүйлийн 7.6.3 дахь “холбогдох акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн явц”-ыг тайлагнана гэж дүрэмд заасныг хэрэгжүүлээгүй байна.



Дээрх үзүүлэлтээс харахад 2016-2020 онд нийт 656,283.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож төсвийн орлогот 592,010.2 мянган төгрөгийг төвлөрүүлж 2020 оны жилийн эцэст 64,274.6 мянган төгрөгийн төлбөрийн актын үлдэгдэлтэй 9.8 хувийн гүйцэтгэлийн хэрэгжилт дутуу байгаад хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Төлбөрийн актын бүртгэлийн маягтаас 2020 жилийн эцсийн үлдэгдэл болох 64,274.6 мянган төгрөг нь хэдэн оны төлбөрийн актын үлдэгдэл байгаа нь харагдах боломжгүй байна.



Дээрх үзүүлэлтээс харахад 2016-2020 онд хугацаатай албан шаардлагыг 100 хувийн гүйцэтгэлтэй харагдаж байгаа ч албан шаардлагын биелэлтийг

тооцохдоо албан бичгээр хаадаг, албан шаардлагын мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын нотлох баримт хангалтгүй байна.

Энэ нь төрийн захиргааны төв байгууллага нь албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам байхгүй, бүртгэл хөтлөх загвар маягтыг боловсруулан батлаагүй байгаа нь төлбөрийн актын үлдэгдлийн төрлийг байгааг харах боломжгүй, албан шаардлагын биелэлтийг хэрхэн тооцох хууль эрх зүйн орчин нь дутмагтай холбоотой байна.

Төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж, Сангийн яаманд хүргүүлдэг бөгөөд дүрэмд зааснаар акт, албан шаардлага, зөвлөмж, түүний мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтэд улирал тутам хяналт тавьж ажиллана гэснийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

А.2.2.3. Санхүү хяналт дотоод аудитын албаны хяналт шалгалтаар илэрсэн төлбөрийн акт, албан шаардлагаар тогтоосон зөрчил дутагдал дахин давтагдаж байгаа нь хяналтын үр нөлөөг бууруулж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.4 д` эх “Сангийн яам нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд баримтын иж бүрэн шалгалтыг 2 жил тутам нэгээс доошгүй удаа заавал хийх ба шалгалтын дүнг хамтран хэлэлцэж шаардлагатай арга хэмжээ авна” гэсэн заалтад үндэслэн Санхүү хяналт дотоод аудитын албанаас 2016-2020 онд нийт 246 байгууллагат хяналт шалгалт хийжээ. Үүнээс 4 байгууллага, 6 суманд 2-3 жилийн давтамжтай хяналт шалгалтад хамруулсан байна.

Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах Төлбөрийн акт, хугацаатай албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн ч төлбөрийн актын биелэлт дутуу, албан шаардлагын хариу хангалтгүй, шалгадагч байгууллагын албан тушаалтны ажлын хариуцлагагүй зэргээс хяналтын үр нөлөөг бууруулж байна. Тухайлбал:

- ГХБХБГ-т 2016 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийснээр анхан шатны баримтын бүрдэл дутуу зардалд 2 төлбөрийн акт тогтоож ажилласан ч 2020 оны төлөвлөгөөт шалгалтаар дээрх алдаа, зөрчил дахин давтагдан гарсанд хугацаатай албан шаардлага хүргүүлсэн байна;
- Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төвд 2018, 2020 онд хийсэн төлөвлөгөөт шалгалтаар өглөг, авлагыг бүртгээгүй зөрчил давтан гаргаж байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, 14.4.3 дугаар заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна;
- Орхон сумын цэцэрлэгийн эрхлэгч 2018 хийсэн хяналт шалгалтаар өөрөө өөртөө тушаал гаргаж хөнгөлөлт, урамшууллыг авч байна;
- Орхон сумын ЗДТГ-т 2018 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж албан томилолтын анхан шатны баримтын бүрдэлгүй зөрчилд төлбөрийн акт оногдуулан ажилласан ч 2020 оны төлөвлөгөөт шалгалтаар уг алдаа зөрчил арилаагүй байна;
- Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуульд 2018 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж анхан шатны баримтын бүрдэлгүй зөрчилд төлбөрийн акт оногдуулан ажилласан ч 2020 оны төлөвлөгөөт шалгалтаар анхан шатны баримтын бүрдэлгүй зөрчил дахин гарсаар байна.

Байгууллагын санал:

- Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт гэсэн ч зөвхөн манай байгууллагын талаар бичигдсэн.
- Тайлангийн А.1.1.1-ийн 6-д шалгагдагч байгууллагатай маргааны улмаас хүчингүй болсон, акт, албан шаардлага байхгүй.
- Дүгнэлтийн 6-д дотоод аудитор байхгүй гэдгийн оронд дотоод аудиторгүйгээс гэж өөрчлөх
- Дүгнэлт хэсэгт СХАА-ны тогтолцоог шийдвэрлэх санал оруулах /Босоо тогтолцоотой болох, санхүүжилтийн асуудал, орон нутагт Засаг даргын дэргэдэх алба буюу орон нутгаас санхүүжилт авч байгаа талаар/

Саналд өгсөн тайлбар:

Аймгийн санхүүгийн хяналт, аудитын албанаас ирүүлсэн 4 саналыг аудитын баг нягтлан үзэж 1 саналыг хүлээн авч тайланд зохих найруулгын өөрчлөлт оруулсан бөгөөд 3 саналыг хүлээн авах боломжгүй тул дараах тайлбарыг өгч байна.

Саналд өгөх тайлбар	
БуААГ-ын тайлбар 1	Санхүүгийн хяналт, аудитын албанаас бусад төрийн байгууллагуудын хувьд дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа тул аудитын сэдвийн дагуу хамрах хүрээг хязгаарласан бөгөөд саналыг хүлээн авах боломжгүй байна.
БуААГ-ын тайлбар 2	Тайлангийн 11 дүгээр хуудасны 12 дахь мөрийн өгүүлбэрийг ...хүчингүй болох эрсдэлтэй гэж найруулгын өөрчлөлт орууллаа.
БуААГ-ын тайлбар 3	Тайлангийн 23 дугаар хуудасны 20 дахь мөрний дотоод аудитор байхгүй гэсэн үг нь дотоод аудиторгүйгээс гэсэн үгтэй утгын хувьд адилхан тул хэвээр үлдээсэн.
БуААГ-ын тайлбар 4	Тайлангийн нэгдсэн дүгнэлтэд СХАА-ын тогтолцоо, хууль эрх зүйн талаар дурдсан болно.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Дотоод аудитын хууль эрх зүйн орчныг тодорхой болгож дотоод аудитын эрх зүйн бие даасан дотоод аудитын тухай хуультай болох шаардлагатай байна;
- Дотоод аудитын нэгж нь үйл ажиллагаагаа дүрэм, стандартын дагуу явуулж байгаа ч дотоод аудитын дүрмийн 7.1, 7.2, 7.6 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, дотоод аудитын дүрэмд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын зарим стандарт тусгагдаагүй;
- Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод аудитын дүрэмгүй;
- Санхүүгийн хяналт, аудитын алба аудитын дүрэм, бусад стандартад заагдсан дотоод аудитын чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд хөрөнгө, хүний нөөц, хүрэлцдэггүй, хангалтгүй;
- Зохион байгуулалт, хууль эрх зүйн орчноос хамаарч хараат бус байдал алдагдах, ашиг сонирхлын зөрчил гарах, ажлын үнэн зөв, бодиттой байх зарчим алдагдах эрсдэлтэй;
- Дотоод аудитын хороо нь санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагааг хараат бусаар удирдах, хэрэгжүүлэх, хянах, тайлагнах, зохион байгуулалтын хараат бус байдлыг хангах эрх үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй;
- “Дотоод аудитын дүрэм”-ын 4.4-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасан дотоод аудитор байхгүй, дотоод аудитын дүрэмд заасан дотоод аудитын чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй;
- Хяналт шалгалтын үр дүнг мэдээлэх Facebook, <http://sankhuuhyanal.bu.gov.mn> цахим хаяг байгаа боловч олон нийтэд, ил тод мэдээлэх ажил хангалтгүй, мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна;
- Төрийн захиргааны төв байгууллагаас дотоод аудитын үр дүнд үнэлгээ хийж, дүгнэлт өгч ажиллаагүй;
- Албан шаардлагын биелэлт 100 хувь, төлбөрийн актын биелэлт 90.2 хувьтай биелсэн ч 2016-2020 оны актуудыг барагдуулаагүй, актын үлдэгдлийг тооцсон бүртгэл хөтлөөгүй, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал дахин давтагдаж байгаа нь хяналт, шалгалтын үр нөлөөг бууруулж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:

- Дотоод аудитын хорооны дүрэм, дотоод аудитын нэгжийн дүрмийг ДАМПОУС –д нийцүүлэн засаглалын үр нөлөө, үр ашиг, эрсдэлийн удирдлага болон хяналтын үйл явцад хувь нэмэр оруулж байхаар өөрчлөх, шинэчлэх, дүрмийн хэрэгжилт, зохион байгуулалтын хараат бус байдлыг хангах эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлэх, хороог тогтмол хуралдуулж хэвших;
- Дотоод аудитын албыг чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх бүтэц, орон тоо, төсөв, хөрөнгийн судалгааг хийж холбогдох стандарт, дүрэмд нийцүүлэн батлах;

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГАД:

- Дотоод аудитын нэгжийн дотоод аудитын өөрийн нэгжийн дүрмийг холбогдох стандарт дүрэмд, нийцүүлж батлах, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ улсын салбарын дотоод аудитын гарын авлагыг ашиглах;
- Дотоод аудитын дүрэмд заасан дунд хугацааны төлөвлөгөөг батлуулах, хяналт шалгалтын удирдамжийг төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулах, төлөвлөсөн дотоод аудитыг хэрэгжүүлж дотоод аудитын хороонд үйл ажиллагаагаа танилцуулж байх;
- Хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.5²² дахь заалтын дагуу баг бүрэлдэхүүнийг байгуулж, хяналт шалгалтын явцад үе шатны хяналтыг хийж байх;
- Хяналт шалгалтын танилцуулгыг тухай бүр олон нийтэд хүртээмжтэй байхаар мэдээлэх, өмнөх оны танилцуулгыг веб сайтад нөхөн байршуулах;
- Шалгагдагч этгээдээс ирүүлсэн баримт нотолгоонд үндэслэн албан шаардлага, төлбөрийн актыг хэрэгжилтийг тооцон архивын нэгж үүсгэх;

²² 5.2.5.шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч;

Хавсралтууд:



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 07 өдөр Дугаар А/21 Булган

┌ Аудитын тайлан баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/27 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө", 2018 оны А/221 дүгээр тушаалаар баталсан "Аудитын чанарын хяналтын журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний дагуу Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтийн үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Гүйцэтгэлийн аудитын тайланг Аймгийн засаг дарга, Санхүүгийн хяналт аудитын албаны даргад хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2022 оны 04 дугаар сарын 15-ний дотор ирүүлэхийг Аймгийн засаг дарга Б.Ариун-Эрдэнэ, Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Б.Баттулга нарт даалгасугай.
4. Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж, биелэлтийг тооцон хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ж.Энхцоодол/-д даалгасугай.
5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, Төрийн аудитын байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд түгээхийг ахлах аудитор /Г.Намчинсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР

D: /bnchig hereg/2021/tushaal/TAtushaal.doc
006010096


**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.10.22 № 261
танай _____ -ны № _____ -т

Г АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Т
Б.АРИУН-ЭРДЭНЭ ТАНАА

"Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын /БУА-2021/15-5-ШТА-ГА/ тайлангийн төслийг хавсралтаар хүргүүлж байна.
Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасны дагуу саналаа ирүүлнэ үү.

Хавсралт... хуудастай

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР

6317144796
ГЮА0048 3190269

006030112
D/bichig hereg/2021/A5toot

185-



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
АУДИТЫН АЛБА**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Чин Ван Ханддоржийн талбай, Утас: 7034-2244,
E-mail: sankhuu_audit_bu@yahoo.com

2021.10.29 № 73
Танай _____-ны № _____

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**


Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт тайланг уншиж танилцлаа. Дараах байдлуудыг эргэн харах Үүнд:

1. Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт гэсэн ч зөвхөн манай байгууллагын талаар бичигдсэн
2. Тайлангийн А.1.1.1-ийн 6-д шалгадагч байгууллагатай маргааны улмаас хүчингүй болсон акт, албан шаардлага байхгүй
3. Дүгнэлтийн 6-д дотоод аудитор байхгүй гэдгийн оронд дотоод аудиторгүйгээс

Санал: Дүгнэлт хэсэгт СХАА-ны тогтолцоог шийдвэрлэх санал оруулах /Босоо тогтолцоотой болох, санхүүжилтийн асуудал, орон нутагт Засаг даргын дэргэдэх алба буюу орон нутгаас санхүүжилт авч байгаа талаар/

ДАРГА

Б.БАТТУЛГА



2021053